



Байгаль орчны үнэлгээ,
мониторинг, зөвлөх үйлчилгээ

ПРОМОН ТРЕЙД” ХХК-ИЙН “МАЛЫН
ГАРАЛТАЙ ЯС, ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮН
БОЛОВСРУУЛАХ ПРОТЕЙН ҮЙЛДВЭРИЙН”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот
2026 он

БАТЛАВ

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Г.ЭНХМӨНХ

ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Б.ГАНБОЛД

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

ПРОМОН ТРЕЙД ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.БАТТОГТОХ

**ПРОМОН ТРЕЙД” ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “МАЛЫН ГАРАЛТАЙ ЯС,
ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОВСРУУЛАХ ПРОТЕЙН ҮЙЛДВЭРИЙН”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ
(5357624)**

БОЛОВСРУУЛСАН:

ЭКО ЭСТИМЭЙТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Д.АЛТАНГЭРЭЛ

Гарчиг

НЭГ. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1.Төсөл хэрэгжих талбайн газарзүйн онцлог.....	5
2.2. Төсөл хэрэгжих талбайн геологийн тогтоц.....	5
2.3. Цэвдэг	5
2.4. Геоморфологи	5
2.5. Тектоник.....	6
2.6. Уур амьсгал	6
2.7. Гадаргын болон газрын доорх үс	6
2.8. Ургамлан нөмрөг	7
2.9. Хөрс.....	7
2.10. Амьтны аймаг	7
1.12. Түүх, соёлын дурсгалт зүйлс	7
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
3.1. Төслийн талбайн нөлөөллийн бүс	8
3.2. Үйлдвэрийн үйл ажиллагааны байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол нөлөөлөл.....	9
3.3. Болзошгүй нөлөөллийн үнэлгээ	10
3.4. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх гол нөлөөлөл.....	12
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	20
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	23



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн нөлөөллийн цар, хүрээ.....	9
Зураг 2. Эрүүл ахуйн хамгаалалтын бүс	12
Зураг 3. Газар хөдлөлт болон бусад аюулын үед анхааруулах дохиогоор цугларах цэг	19

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Туул голын морфологийн үндсэн элемент.....	5
Хүснэгт 2. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим.....	9
Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын тооцоо	13
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын төлөвлөгөө.....	14
Хүснэгт 5. Ногоон байгууламжийн төлөвлөгөө.....	16
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	21
Хүснэгт 8. БОМТ-ыг оролцогч талуудад тайлагнах хуваарь	23



НЭГ. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Малын гаралтай яс, дайвар бүтээгдэхүүн боловсруулах протейн үйлдвэр нь Италийн IMPIANTI CARRERA компанийн бүрэн автомат Тоног төхөөрөмжийг 2019 онд цогцоор нь нэвтрүүлж Европын Холбооны Улсуудад дагаж мөрддөг стандартуудыг бүрэн хангасан, Ази тивд 2-т орох түвшний бүрэн автомат үйлдвэрийг 2019 оны 2-р сарын 15-ны өдөр нээлтээ хийгээд, үйл ажиллагаагаа явуулж байна. Малын гаралтай яс, дайвар бүтээгдэхүүн боловсруулах протейн үйлдвэр хоногт 100 тн малын яс боловсруулах хүчин чадалтай, үйлдвэрлэлийн явцад хог хаягдал гардаггүй ЭКО үйлдвэр юм. Үйлдвэр нь хоногт 100 тонн, жилд 36 мянган тонн түүхий эдийг хүлээн авч, 100% дахин боловсруулснаар жилд дунджаар

- 12000 тн мал амьтны уурагт тэжээл болон органик бордоо,
- 6000 тн малын гаралтай тос үйлдвэрлэх хүчин чадалтай.

Одоогоор экспорт хийхгүй байгаатай холбоотойгоор үйлдвэр нийт хүчин чадлын 15%-иар ажиллаж байгаа бөгөөд зөвхөн үйлдвэрийн албанд 25 орчим ажилтан тогтмол ажиллаж байна.

Бүрэн автомат Малын гаралтай яс, дайвар бүтээгдэхүүн боловсруулах протейн үйлдвэр нь Европын холбооны шаардлагыг хангасан 6 шат дамжлагатайгаар боловсруулалт хийдэг. Үүнд:

- Түүхий эдийг 5см-6см хэмжээтэй бутална.
- 10 барын даралтаар 133°C -140°C температурт 30 минутаас багагүй хугацаанд чанаж ариутгана.
- Шахагч машинаар тосыг шахаж гаргана.
- Гарсан тосыг цэвэршүүлнэ.
- Тэжээлийг тээрэмдэнэ.
- Тэжээлийг савлана.

Төслийн барилга байгууламж:

- Үйлдвэрийн барилга (2 давхар) – 1800 м²
- Уурын зуухны барилга – 250 м². 4 тн/ц болон 6 тн/ц хүчин чадал бүхий 2 уурын зуухтай
- Насос станцын барилга – 90 м². Бүрэн автомат усан хангамжийн системтэй
- Цэвэр усны нөөцлүүр танк – 25 м³
- Тос хадгалах танкууд – 1800 м³
- Түүхий эдийн агуулах – 1080 м³
- Ажилчдын амралтын байр (буудал, цайны газар, фитнес – 360 м²

Үйлдвэрлэлийн дэд бүтэц:

- Ус – MNS 0900:2018 стандартад нийцсэн гүний устай
- Уур – Технологийн 10.0 бар ханасан уур (уурын зууханд үйлдвэрлэдэг)
- Эрчим хүч – Төвийн цахилгаан сүлжээнд холбогдсон. Нөөц 360 кВ дизель үүсгүүртэй

Түүхий эд: Адуу, үхэр, хонь, ямаа, тэмээ зэрэг амьтдын EU 142/2011 стандартын дагуу 3-р Категорийн эрүүл ахуйн шаардлага хангасан дайвар бүтээгдэхүүн (яс, өөх, мах, цус).

“Промон трейд” ХХК-ийн төслийн хүрээнд Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн голлох үхэр, хонь, адууны яс, мах болон малын шийр, толгой, гэдэс дотор зэрэг дайвар бүтээгдэхүүн буюу түүхий эдийг хүнсний зориулалтаар мах бэлтгэдэг улсын тусгай зөвшөөрөлтэй махны үйлдвэрүүд болон мах бэлтгэн экспортод гаргадаг махны үйлдвэрүүдээс шууд татан авч дэвшилтэт технологийн дагуу эцсийн бүтээгдэхүүн болох “ясны тос”, “ясны гурил (уураг)”, “Бона бордоо” зэргийг боловсруулж зах зээлд нийлүүлдэг.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1.Төсөл хэрэгжих талбайн газарзүйн онцлог

Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны шувтрах үзүүр, Асралтхайрхан (2799 метр) уулын өвөр талаар Богдхан уулын ар хормойд (дундаж өндөр нь 1350 метр) Туул голын сав газарт байрлах бөгөөд Чингэлтэй уул (1949 метр), Баянзүрх уул (1834 метр), Богдхануул (2256 метр), Сонгинохайрхан уул (1652 метр) гэсэн уулуудаар хүрээлэгдэж оршино. Нийслэл Улаанбаатар хотын барилгажсан ба барилгажих талбай нь далайн түвшнээс дээш 1260-1350 метр өндөр, газрын гадаргуу нь бүхэлдээ хойд уулсаас Туул голын сав хөндий чиглэсэн налуугийн тогтолцоотой юм.

2.2. Төсөл хэрэгжих талбайн геологийн тогтоц

Улаанбаатар хот орчмын геологийн тогтоц нь доод палеозейн Хараа формаци, дунд, дээд палеозейн Хэнтий формаци, дунд тормолийн боржин, цэрдийн Зүүнбаян формаци, кайнозойн хурдаснаас бүрдэнэ. Туул гол болон түүний цутгалуудын дагуух газар голын усаар зөөгдөж ирсэн элс, хайрга, шавар зэрэг хурдсаар бүрхэгдсэн байдаг. Судалгааны талбайн орчим нь геологийн цаг тооллоор Дээд дунд-Кембрийн үед үүсэн тогтож өнөөгийн гадаргын хэлбэр дүрсийг олсон бөгөөд төсөл хэрэгжих газарт интрузив гранитойд буюу шургамал боржингийн чулуулгийн массив тогтсон нь ажиглагдаж байгаа юм. Делюви-Пролювийн гарал үүсэлтэй дээд плейстоцен-орчин үеийн сэвсгэр хурдас

2.3. Цэвдэг

Улаанбаатар хотод улирлын ба олон жилийн цэвдэг үл хөрс, чулуулаг тархсан байдаг. Манай орны цэвдэг дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст тархсан олон жилийн цэвдгийн өмнө хил болдог учраас Сибирийн мөнх цэвдгийг бодвол өндөр температуртай, байгалийн хүчин зүйл болон хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөнд амархан өртөж хувирч өөрчлөгддөг онцлогтой. Ийм учраас тус газарт тархсан улирлын ба олон жилийн цэвдгийг судалж түүний нөлөөнөөс урьдчилан сэргийлж байгаль хамгаалахад цэвдгийн нөхцөлийг зайлшгүй тооцож байх шаардлагатай.

2.4. Геоморфологи

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр геоморфологийн тогтцын хувьд энгийн боловч түүний онцлог, динамик хэлбэлзлийг тодорхойлоход Туул голын хөндийн морфологи чухал ач холбогдолтой. Төсөл хэрэгжих талбай нь Туул голын татмын дээрх 1 дэнжийн хэсэгт байрлах ба газрын гадарга нь хойноосоо урагшаа бага зэрэг хэвгий тогтоцтой байна. Талбайн хэмжээнд орчин үеийн физик-геологийн үзэгдэл үйл явц хөгжөөгүй. Туул голын хөндийн морфологийн үндсэн элементүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Туул голын морфологийн үндсэн элемент

№	Туулын татам дэнжийн нэр	Өндрийн хэмжээ, м	нас
1	Нам татам	1.5	Q _{IV}
2	Өндөр татам	3	Q _{IV}
3	Татмын дээрх 1 дэнж (Амгалангийн)	5	Q _{IV}
4	Татмын дээрх II дэнж (Улаанбаатарын)	8-9	Q _{III} ²
5	Татмын дээрх III дэнж (Зайсангийн)	11-12	Q _{III} ²
6	Татмын дээрх IV дэнж	15-16	Q _{III} ²

Гадаргуугийн тектоник-денудацийн гарал үүслийн төрөлд Богд уулын ар хажуугийн болон бусад голын хөндийн захын тектоник шилжилтийн хажуунууд, денудаци-хуримтлалын төрөлд усан

хагалбарын хажуугийн дунд, доод хэсэг ба бэл- хормойн хурдас тархсан хэсгүүд, хуримтлалын төрөлд голуудын хөндий газрууд тус тус хамаарагдана.

2.5. Тектоник

Улаанбаатарын районы тектоник тогтоц Хэнтийн уулархаг нутгийн неотектоник хөгжилтэй шууд холбоотой бөгөөд неоструктурын ерөнхий төлөвийг Улаанбаатарын грабень, түүнийг хүрээлэн орших блоклог өргөгдлүүд тодорхойлно. Тектоник тогтцын хувьд тус нутаг энгийн бөгөөд Мезозойн өмнөх, Мезо-Кайнозойн структурын давхаргуудаас тогтоно. Мезозойн өмнөх структурын давхарга нь тус нутгийн кристаллаг фундаментыг үүсгэх бөгөөд түүний бүрдэлд доод Карбоны тунамал чулуулаг зонхилж, гол төлөв зүүн хойт, баруун хойт чиглэлтэй тектоник хагарлуудаар хэрчигдэж дотоод тогтоц нь нийлмэл болсон байна. Мезо-Кайнозойн структурын давхарга нь кристаллаг фундамент дээр үүсэж гол төлөв томоохон голын грабень хэлбэрийн хөндийг дүүргэж оршино. Структурын энэ давхаргын дотоод тогтоцыг доод Цэрд, Неоген, Дөрөвдөгчийн структур, формацийн комплекс бүрдүүлнэ. Тус нутгийн тектоник тогтоцод түрүү Мезозойн интрузив бүрдэл бие даасан стрүктүр үүсгэнэ. Улаанбаатарын районы тектоник структурыг гүний хагарлууд тодорхойлж, давхаргууд гол төлөв гүний хагарлаар зааглагдана.

2.6. Уур амьсгал

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Промонтрейд” ХХК-ийн эзэмшил бүхий газрын байгаль орчны судалгааны тайлангийн хувьд уур амьсгалын суурь үнэлгээг өгөхдөө Улаанбаатар хот орчмын үндсэн нөхцөл байдлыг суурь болгон авч үзэв. Нийслэл “Улаанбаатар” хотыг бичил уур амьсгалын 4 бичил мужид хувааж болох юм гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Хотын төв хэсэг /Их сургууль өртөө/-т их дулааралтын муж, өвөлд байшин барилга, машин, төвлөрсөн халаалт зэрэг хүний хүчин зүйлийн нөлөөгөөр орчноосоо эрс дулаан байдаг. Салхи багатай, нөмөр, цардмал замтай учир зунд их халдаг. Офицерын ордноос 5 шар хүртлэх төв замын хоёр талын хороолол, өндөр барилга бүхий хотын төв хэсэг орно. Агаарын температур, чийг, салхины горим хүний хүчин зүйлийн нөлөөнд өөрчлөгдсөн муж.

Хүйтэн муж /Буянт-Ухаа өртөө/-д зуны халалт хэвийн буюу голын нөлөөгөөр арай бага, өвлийн хүйтрэлт их, голын хөндий, цас мөсний жавар, хөрөлтийн нөлөөнд оршдог Туулын хөндий, Яармагийн дэнж, Буянт-Ухаа орчим багтана.

Өндөр уулын муж /Морин-Уул өртөө/д өндөршлөөс хамааран зун бага халдаг, өвөлд инверсийн нөлөөгөөр бага хөрдөг, салхи ихтэй, аадар тунадас ихтэй Морин-Уул болон дөрвөн уулсын бэл, салбар орой багтана.

Хотын хүрээ /Улаанбаатар өртөө/-нд төв хэсгийн гадуур орших нам барилга, гэр хороолол зэргээс бүрдэх хотын төвийн гадуур хүрээлэн буй уулсын бэлийг хамран үргэлжлэх том, зарим газраа өргөн, зарим газраа нарийн жигд бүс зуйван хүрээ хамаарна. Энэ хэсэгт цаг уурын элемент, үзэгдлийн горим бага алдагдсан боловч хүний хүчин зүйлийн нөлөө илрэнэ.

2.7. Гадаргын болон газрын доорх ус

Нийслэлийн бүс дэх газар доорх усны тархалт, бүрэлдэн тогтолтын ерөнхий зүй тогтол болон геологийн тогтцын суурь нөхцөлийн онцлогийг тусгасан зураглалыг үндэслэн, гидрогеологийн давхарга зүйчлэлийн хувьд дараах үст үе давхарга, үст цогцолборт хамаарна. Үүнд:

- Делюви-Пролвийн гарал үүсэлтэй дээд плейстоцен-орчин үеийн сэвсгэр хурдасны үст үе давхарга (dpQ1-2)
- Туул голын хөндийн аллювийн гаралтай орчин үеийн сэвсгэр хурдсан дахь үст үе давхарга (all. Q дөрөвдөгч)

Ус хангамж. Төсөл нь унд ахуйн болон технологийн хэрэгцээнд ашиглах усан хангамжийг 2017 онд үйлдвэрийн талбайд өрөмдөж гаргасан 1 л/секундийн ундаргатай 96м гүнтэй худгаас хангадаг. 8м³ багтаамжтай цэвэр усны нөөцийн савтай. Гүний худгаас нөөцийн сав руу хоолойгоор холбогдсон. Худаг дээр darg маркийн насосыг 92 м гүнд суурилуулсан. 2018 онд усны тоолуур суурилуулсан.

2.8. Ургамлан нөмрөг

Улаанбаатар хот нь Хэнтийн уулын тайгын тойрог, Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрог гэсэн хоёр тойргийн уулзвар нутагт хамаарна. Хотгор гүдгэрийн мужлалаар Улаанбаатар хотыг тойрон хүрээлэх Хэнтийн нурууны баруун захын салбар дундаж, нам уулс, тэдгээрийг тусгаарлан орших голуудын хөндийгөөс бүрдэнэ. Эдгээр уулс нь Сибирийн геоморфологийн их мужийн Хэнтийн мужид багтах хавтгайдуу оройтой. эрс хажуу бүхий дундаж уулсын системд хамаардаг. Төслийн талбай хашааны дагуу хөл газрын ургамалтай. Машины зогсоол хэсэгт ургамалгүй, хүн, машины нөлөөгөөр эвдэрч халцарсан байна. Цаашид хөрсөн бүрхэвчийг бохирдуулахгүй, агаарт гарах тоосыг бууруулахын тулд талбайг хатуу хучилттай болгох шаардлагатай.Төслийн талбайн хашаа нь дотор ямар ч ургамал байхгүй бөгөөд хашааны гадан талд ургасан ургамал бүхий талбайд ургамлын судалгаа хийсэн.

2.9. Хөрс

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь хөрс-газар зүйн мужлалаар, хөрсний өндрийн бүсшилийн хэв шинж бүхий Хэнтий орчмын 52, 43-р тойргуудад хамаарагдана. Дүүргийн нутаг дэвсгэрийн хойд хэсгээр ойн хөрс, уулын хар шороон, ам хөндийгөөр нуга-намгархаг хөрстэй байхад урд хэсгээр уулын хар хүрэн хөрс голчлон тархана. Түүл, Сэлбэ, Дунд, Улиастай зэрэг том жижиг голуудын хөндийгөөр аллювийн хөрстэй.

Энэ орчмын нутаг дэвсгэр нь хөрс-газарзүйн мужлалаараа Хангайн их муж Хэнтийн мужийн Хэнтийн захын хэсгийн тойрогт хамрагдана

Хөрсний хүнд металлын шинжилгээний үзүүлэлтийг хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (Стандарт MNS 5850:2008)-тэй харьцуулан харахад стандартаас даваагүй буюу стандарт хэмжээнд байна.

2.10. Амьтны аймаг

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болох Улаанбаатар хот амьтны аймгийн газарзүйн мужлалаар умардын их мужийн хөвч тайгын дэд мужийн Хэнтийн тойрогт багтана. Судлаачдын тооцоолсноор уг нутагт 50 орчим зүйл хөхтөн амьтадтай. Их хотын чимээ шуугиан, хүн, авто хөсөг, бэлчээр тэжээлийн хүрэлцээ зэргээс шалтгаалан амьтад нэг газар байнга оршин амьдардаггүй улирлын чанартай нүүдэллэн шилждэг онцлогтой.Төсөл хэрэгжих СХД-ийн 32-р хороо нь хүн амын суурьшлын бүс тул шууд нөлөөлөлд өртөх нэн ховор, ховор ан амьтан байхгүй.

1.12. Түүх, соёлын дурсгалт зүйлс

Төслийн талбайн ойр орчим түүх, соёлын дурсгалын ач холбогдолтой ямар нэгэн зүйлс байхгүй болно. Гэвч төслийн үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдох аваас холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны нэгж болон холбогдох байгууллага болох ШУА-ын Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж, төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох шаардлагатай.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх боломжит нөлөөллийг тодорхойлох, тоо хэмжээг тодорхойлохдоо БОНХЯ-ны сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тушаалаар батлагдсан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалд тусгагдсан арга, аргачлалыг ашиглав.

3.1. Төслийн талбайн нөлөөллийн бүс


Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг БОНХ сайдын 2013 оны 11 дүгээр сарын 16 өдрийн 374 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын дагуу төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоосон. Нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоохдоо “Нөлөөлөл орон зайд буурах функц”-ыг ашигласан. Өөрөөр хэлбэл нөлөөлөл нь нөлөөллийн эх үүсвэрээс тодорхой зайд янз бүрийн эрчимшилтэйгээр орон зайд тархана. Тухайлбал, нөлөөллийн эх үүсвэрээс тодорхой зайд нөлөөлөл их хэвээр үргэлжлэх ба нөлөөллийн төрлөөс шалтгаалан нөлөөллийн эрчимшил өөр өөр зайд ялгавартай буурна. Энэхүү орон зайд тархаж буй нөлөөллийн эрчим хоорондоо давхцах үед давхардал нөлөөлөл үүсэх болно.

Талбайн нөлөөллийн орон зай, цаг хугацааны тархалтыг тодорхойлохын тулд ГМС-ийн ArcGIS 10.3 программ дээр нөлөөлөл буурах функц ашиглан нөлөөллийн эрчим, орон зай, цаг хугацааны тархалтыг тодорхойлсон. Үүнд:

$$Function = \left(1 / \left(1 + Exp \left(((Distance/100) - a) * b \right) \right) \right) * Weight$$

Энд: *Distance* - Нөлөөлөл буурах зай, *Weight* - Нөлөөллийн эрчим, *a*, *b* - Налуугийн хүчин зүйлс

Нөлөөлөл буурах зай болон нөлөөллийн эрчим зэрэг нь нөлөөллийн төрөл, газар орны нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байх тул дараах хүснэгтэд үзүүлсэн байдлаар нөлөөлөл буурах зэрэгтэй уялдуулан налуугийн хүчин зүйлсийг сонгож нөлөөлөл буурах функцийг тогтооно.



Зураг 1. Төслийн нөлөөллийн цар, хүрээ

Төслийн нөлөөлөл буурах зайг 1000 метр, нөлөөлөл буурах зэрэг дунд, нөлөөллийн эрчим 300 гэсэн үзүүлэлтүүдийг ашиглан тодорхойлсон бөгөөд нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг их, бага, дунд нөлөөлөлд өртөх хэмжээгээр нь тооцсон. Нөлөөлөл буурах функцээр тооцоход Төслийн үйл ажиллагаанаас их нөлөөлөлд өртөх талбай 27.31 га, дунд зэргийн нөлөөлөлд өртөх талбай 14.42 га, бага нөлөөлөлд өртөх талбай 325.12 га талбайг тус тус эзэлж байна.

3.2. Үйлдвэрийн үйл ажиллагааны байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг нөлөөллийн эх үүсвэрээс нь хамааруулан эрчим, цар хүрээ, хугацаа, шинж чанарыг тодорхойлж тоон ба чанарын шинжилгээ хийв.

Хүснэгт 2. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлтүүд		Нөлөөлөл		Хугацаа		Давталт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Богино	Урт	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1	Төсөл хэрэгжих явцад шингэн хаягдал үүсэх	х			х		х		х	

Байгаль орчны үзүүлэлтүүд		Нөлөөлөл		Хугацаа		Давталт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Богино	Урт	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
2	Төсөл хэрэгжих явцад хатуу хаягдал үүсэх	х			х		х			х
3	Төсөл хэрэгжих явцад хортой, аюултай хог хаягдал үүсэх	х			х		х			х
4	Төслийн хүрээнд усны нөөцийг ашиглах	х			х		х		х	
5	Төслийн хүрээнд эрчим хүчний нөөцийг ашиглах	х			х		х		х	
6	Төслийн хүрээнд дуу чимээ, доргио чичиргээ үүсэх	х			х		х			х
7	Агаарт бохирдуулагчид/үнэр, дуу чимээ, хортой хий ялгарах	х		+			х			х
8	Төслийн хүрээнд нүүрсний нөөц ашиглах	х			х		х		х	
9	Төсөл хэрэгжүүлэх явцад хөрс элэгдэх, эвдрэх	х		х			х			х
10	Байгаль орчны бохирдол бууруулах /бохир ус цэвэршүүлэх/	+				х		+		
11	Нийгэм, эдийн засагт эергээр нөлөөлөх /бүтээгдэхүүн үйлдвэрлэл өсөх/	+				х			+	
12	Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх	+				х			+	
13	Шинээр ажлын байр бий болох	+		+		х				+
14	Орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх	+				х			+	
15	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+	+	+		х				+
Нийт		14	1	4	1 1	6	9	1	7	7

Тайлбар: (х) - сөрөг нөлөө (+) - эерэг нөлөө

Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол нөлөөллүүдийн хувьд шууд байдлаар сөргөөр нөлөөлөх 9, шууд байдлаар эерэг нөлөөлөх 6 нөлөөлөл байна. Нөлөөллийн хугацааны хувьд 73% нь урт хугацааны, 27% нь богино хугацааны, буцалтгүй нөлөөлөл нийт нөлөөллийн 60%, буцаж нөлөөлөх эерэг нөлөөллүүд 40%-ийг түс түс эзэлж байна. Төсөл хэрэгжих явцад шингэн хаягдал гарах, усны нөөц, нүүрсний нөөц, эрчим хүчний нөөц ашиглах нь дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл, хатуу болон хортой аюултай химийн бодисын хаягдал үүсэх, дуу чимээ, доргио чичиргээ үүсэх, агаарт үнэр, хортой хийн хаягдал үүсэх, хөрс элэгдэх эвдрэх нь сул эрчимтэй сөрөг нөлөөллүүд байна.

Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, хөгжилд дэмжлэг үзүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэл өсөх нь дунд зэргийн эрчимтэй эерэг, шинээр ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулахад дэмжлэг болох нь сул эрчимтэй эерэг нөлөөллүүд байна.

3.3. Болзошгүй нөлөөллийн үнэлгээ

Төслийн шийдэл болон байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн магадлан жагсаах аргаар нөлөөллийн үр дагаврыг бага, дунд, их гэсэн утгуудаар илэрхийлэн, үр дүнг хүснэгтээр үзүүлэв.



Хүснэгт 1. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэх үеийн болзошгүй нөлөөлөл

№	Байгаль орчны асуудлууд	Нөлөөллийн үр дагавар			
		Байхгүй	Бага	Дунд	Их
1	Голын голдирол өөрчлөх, булаг шанд хатах, ой мод огтлох гэмтээх	х			
2	Хүн амыг нүүлгэн шилжүүлэх	х			
3	Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллага, үйл ажиллагаатай зөрчилдөх	х			
Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой					
4	Төслийн үйл ажиллагаа нь тухайн орон нутагт нийцэх эсэх, түүхий эд хэмнэх, бохирдол бууруулахад сонгосон техник, тоног төхөөрөмжийн зохицол				х
5	Үйлдвэрлэлийн осол мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудал				х
6	Ус, агаар, хөрс бохирдох асуудал		х		
7	Хатуу хог хаягдлын асуудал			х	
8	Дуу чимээ гарах асуудал			х	
9	Агаарын чанарыг хамгаалах асуудал				х
Барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбоотой					
10	Барилгын үед усны бохирдох байдал		х		
11	Барилгын үед болон дараа хөрсний элэгдэл, эвдрэлийн байдал			х	
12	Барилгын үед машин, механизмын ялгаруулах дуу чимээ, тоос болон хорт хий хаягдал			х	
13	Барилгын үеийн хог хаягдал			х	
14	Үйлдвэрлэлийн осол, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах асуудал				х
15	Химийн бодисоос ажилчдыг хамгаалах асуудал				х
Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой					
16	Хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд тусгагдсан байдал				х
17	Цэвэршүүлсэн ус нь агаар, ус, хөрсний чанарт нөлөөлөл		х		
18	Цэвэршүүлээгүй бохир ус нь агаар, ус, хөрсний чанарт нөлөөлөл				х
19	Биологийн цэвэршүүлэгчийн явцад ялгарах эвгүй үнэр				х
20	Биологийн цэвэршүүлэгчийн явцад ялгарах хаягдал лаг				х
21	Шуурхай хяналтын асуудал (төсөлд гэнэтийн осол, хортой нөхцөлийн үеийн зардал)				х
22	Төсөл хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүүгийн боломжийн талаарх асуудал			х	
Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуур					
23	Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой захиргааны болон эдийн засгийн зохицуулалт				х

№	Байгаль орчны асуудлууд	Нөлөөллийн үр дагавар			
		Байхгүй	Бага	Дунд	Их
24	Төслийн техник, технологийн шийдлийг олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				х
25	Төслийн нийгэм, эдийн засагт эергээр нөлөөлөх эсэх				х

Нийт барилга, байгууламжийн хэмжээгээр хөрс элэгдэл, эвдрэлд өртөж байгаа тул төсөл хэрэгжүүлэгч нь “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн дагуу эзэмшил газрын 10%-аас доошгүй талбайд мод тарих, зүлэгжүүлэх шаардлагатай. Үйл ажиллагаанаас ялгарах хатуу хог хаягдлыг журмын дагуу зайлуулж устгах, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж байх нь зүйтэй. Инженерийн шугам сүлжээний бүрэн бүтэн байдлыг хангахын тулд тогтмол хугацаанд үзлэг, хяналт хийх шаардлагатай. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага MNS 5105:2001 стандарт шаардлагад Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээг үйлдвэр тус бүрээр тусгасны дагуу тухайн төсөл нь Аж ахуйн нэгж, байгууллагын эрүүл ахуйн хамгаалалтын 4-р бүсэд орж байна. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ 100м.



Зураг 2. Эрүүл ахуйн хамгаалалтын бүс

3.4. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх гол нөлөөлөл

Төслийн явцад байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлж болзошгүй эрсдэлийг тодорхойлох зорилгоор төслийн эдэлбэр газар, ойр орчмоос авсан ус, хөрс, агаарын хяналтын дээж тэдгээрийн шинжилгээний дүнд үндэслэн тэдгээрт агуулагдах бохирдуулагчийн үнэлгээг хийлээ. Төсөл хэрэгжих хугацаанд хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөг, амьтны аймаг усан орчин зэрэг байгалийн бүрэлдэхүүн хэсэгт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй тул үйл ажиллагааны явцад анхаарч ажиллах тодорхой нөхцөлүүдийг дэвшүүллээ.

Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын тооцоо

№	Байгаль орчны менежмент төлөвлөгөөний задаргаа	2026
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал, сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө	4,753 000
2	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлах зардал	4,400 000
3	Хог хаягдлын менежментийг сайжруулах	1 000 000
4	Олон нийтэд тайлагнах хуваарь	1 000 000
5	Удирдлага зохион байгуулалтын зардал	1 000 000
6	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	5,000 000
Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал		17,153 000

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй “Промон трэйд” ХХК-ны Малын гаралтай яс, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдлын болон ерөнхий үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг арилгах, бууруулах, сөрөг нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээний төлөвлөгөө, түүнд шаардагдах зардал, баримтлах хууль эрх зүй, стандартын шаардлага зэргийг үндэслэн боловсрууллаа.

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын төлөвлөгөө

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
			2026	
Агаарын чанар				
Дотоод орчны агаарын чанарын стандарт хэмжээг давах	Дотоод орчны агаарын чанарын хяналт шинжилгээг тогтмол хийх, үйлдвэрийн агааржуулалтын системийг сайжруулах	1 053 000,0	Дулааны улиралд хэмжилт, шинжилгээ тогтмол хийх	MNS 4585:2025 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн шаардлага
	Төслийн үйл ажиллагаанаас гадаад орчны агаарыг бохирдуулах		Бохирдуулагчдын эх үүсвэрийг бууруулах	
Агаарын чанарыг сайжруулах, бохирдлын эх үүсгэврийг бууруулах	Үйлдвэрийн авто тээврийн хэрэгслийг тогтмол хяналтын үзлэгт оруулах, Евро стандартын шатахуун хэрэглэх	Үйл ажиллагааны зардалд тусгах	1-2 авто машин (Жилийн түрш)	-
Түүхий эд хүлээн авах, түр хадгалах процессоос үнэр тархах	Хөргүүр бүхий зоорь, агуулахыг тогтмол ашиглалтад оруулах	Үйл ажиллагааны зардалд тусгах	Тогтмол ашиглах	-
Усан орчин (Гадаргын болон газрын доорх)				
Усны хэт их хэрэглээ үүсэх	Усыг үр ашигтай хэрэглэх талаар ажилчдад сургалт явуулах,	Үйл ажиллагааны зардалд тусгах	0.2 (8 болон 10 сард)	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хувийн хамгаалах



Промон трейд” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Малын гаралтай яс, дайвар бүтээгдэхүүн боловсруулах протейн үйлдвэрийн” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
			2026	
	мэдээллийн хуудсыг ажлын байр, нийтийн бие засах газар, гал тогооны хэсэгт байрлуулах			хувцас хэрэгсэл. Амьсгал хамгаалах хэрэгслийн сонголт, хэрэглээнд тавих ерөнхий шаардлага MNS 6654-2017
Ус хэмнэх талаар	Ажилчдын хэрэглээний усыг хэмнэх зорилгоор автомат ус хаагч, холигч суурилуулах	500 000	Ажилчдын байр, үйлдвэрийн байрны хэрэглээнд (10 сард)	Стандарт үгүй
Хөрсөн бүрхэвч				
Машин техникийн хөдөлгөөнөөс хөрс эвдрэх	Хашаанд зогсоолын хэсгийг цементлэх, тогтсон замаар зорчих	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жилийн турш	Стандарт үгүй
Ургамлын нөмрөг				
Зүлэгжүүлэлт хийхдээ харь зүйл ургамлын үр ашиглах, тэдгээр нь хашааны гадна тархах, орчны ургамалд сөргөөр нөлөөлөх	Зүлэгжүүлэлтийн болон ногоон байгууламжийн ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Үйл ажиллагааны зардалд тусгах	Ногоон байгууламжийн төлөвлөгөөний хэсэгт зардлыг тооцсон болно. (5 болон 9 сард)	MNS 6139:2010 MNS 6141:2010
Ажилчдын эрүүл мэнд				
Үйлдвэрлэлийн үе шатад үүсэх тоосжилт болон тоног төхөөрөмжөөс үүсэх дуу чимээ нь ажилчдын эрүүл мэндэд урт хугацаандаа сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлал бага түвшинд байна.	Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах зориулалттай хувцас, хэрэгслээр тогтмол хангах, тэдгээрийн зааврын дагуу ашиглах талаар сургалт, удирдлагаар хангаж ажиллах.	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүрийн 9 сард	Хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай хууль



Промон трейд” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Малын гаралтай яс, дайвар бүтээгдэхүүн боловсруулах протейн үйлдвэрийн” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
			2026	
	Ажилчдыг жил бүр мэргэжлээс шалтгаалах өвчний үзлэгт хамруулах			
Нийлбэр		4,753,000 (дөрвөн сая долоон зуун тавин гурван мянган төгрөг)		

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих үед ямар нэгэн нэмэлт бүтээн байгуулалтын ажил хийхгүй юм. Гэсэн хэдий ч төсөл хэрэгжих талбайн боломжит хэсгүүдэд шилмүүст болон навчит мод тарих, зүлэгжүүлэх ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн болно. Ингэхдээ ойн эсвэл байгаль орчны мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар доорх зураг төсөл, арга зүйн дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай.

Ногоон байгууламжийн ажлын нийт зардал **[4,400,000₮ Дөрвөн сая дөрвөн зуун мянга]** төгрөг бөгөөд үүнийг үйл ажиллагааныхаа бизнес төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй.

Хүснэгт 5. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээн ий цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Талбайд ногоон байгууламж бий болгосноор орчны өнгө төрхийг сайжруулах, бохирдлыг бууруулах, хуулийн хэрэгжилтийг хангах зорилттой.	Ногоон байгууламж байгуулах	260 м²	Суулгац тоогоор	50	Хайлаас 25 ш*20.0 Хүс 25 ш*130.0	0.5	Төслийн эхний жилийн 5 сард болон 10 сард	MNS 6139:2010 MNS 6141:2010



			Зүлэг м ²	260	15.0	3.9	Жил бүр	Зүлэгжүүлэх талбай бэлдэх, үр тарих арчлах (MNS 6260:2011)
Нийт зардал:		4,400,000₮ Дөрвөн сая дөрвөн зуун мянга						

ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжиж буй байршил нь суурьшлын бүсэд учир түүх соёлын өв, мөн нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагагүй болно.

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бетон зуурмагийн үйлдвэрийн төслийн бүхий л үе шатанд ажлын байрны дотоод дүрмийг боловсруулж хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн инженер хяналт тавьж ажиллах бөгөөд дараах үйл ажиллагааг өдөр бүр хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах үүднээс нэг бүрийн хамгаалах хэрэгслээр тогтмол хангахаас гадна, тэдгээрийг зөв хэрэглэж сурах талаар сургалт тогтмол өгөх

Нэг бүрийн хамгаалах хэрэгсэлд дараах зүйлс хамаарна. Үүнд:

Хатуу малгай	Нүдний шил	Чих хамгаалах хэрэгсэл	Түлэгдэхгүй сайн чанарын бээлий	Тоос шүүх зориулалттай амьсгал хамгаалах хэрэгсэл	Төмөр хамгаалалттай ажлын гутал
					

- Ажлын байрны онцлогоос хамаарч уушги тоосжих, чих дүлийрэх гэх мэт мэргэжлээс шалтгаалах өвчлөл урт хугацаандаа үүсэх магадлалтай тул холбогдох журмын дагуу ажлын байрны өртөлтийн үнэлгээ, үзлэгт тогтмол хамруулж байх
- Ажлын байрны үнэлгээний үр дүнгээс хамаарч шааралддагтай тохиолдолд ажиллах хугацаанд уушги цэвэрлэх, дархлаа дэмжих хүнсний болон нэмэлт бүтээгдэхүүнийг мэргэжлийн эмчийн завраар олгох
- Олон нийтийг хамарсан цар тахлаас урьдчилан сэргийлэх, ажлын байрны эрүүл ахуй, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах талаар зөвлөгөө тогтмол өгөх
- Үйлдвэрлэлийн үе шатанд ашиглаж буй тоног төхөөрөмжийн ажиллах зарчим, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллээр ажилчдыг тогтмол хангах, шинэ ажилчдыг сургалтад хамруулж байх
- Ажлын байрны цахилгааны аюулгүй байдлыг хангаж галын эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж холбогдох тоног төхөөрөмжөөр хангах

төлөвлөж ажиллана. Үүнд:

- Газар хөдлөлтийн үед эзэмшил хашааны төв хэсэгт байрлуулсан цугларах цэг гэсэн тэмдэг бүхий хэсэгт цугларах
- Аянга, цахилгаанаас сэргийлэх зорилгоор өндөрлөг байрлалд аянга газардуулагч байрлуулах
- Барилгын чанар, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг 3 жил тутамд мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж, дүгнэлт гаргуулж байх
- Төсөл хэрэгжих бүс нутаг нь үерийн эрсдэл багатай байрлалд байрлаж байгаа хэдий ч хур борооны улиралд анхаарал болгоомжтой байх нь зүйтэй
- Барилгын дээврийн хийц, болон бусад хэсгийг хүчтэй салхинд нурахаас сэргийлж тогтмол чанарт үзлэг хийж засвар үйлчилгээг гүйцэтгэх





Зураг 3. Газар хөдлөлт болон бусад аюулын үед анхааруулах дохиогоор цугларах цэг

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежмент төлөвлөгөөнд зөвхөн ажилчдын үйл ажиллагаанаас буюу ахуйн чанартай хог хаягдлын эх үүсвэр дээр нь кодын дагуу ангилж холбогдох аж ахуй нэгжүүдэд тушаах, зарим хэсгийг дүүргийн тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулах замаар нийлүүлнэ. Тус үйлдвэрийн үйл ажиллагаанаас ямар нэгэн хог хаягдал үүсэхгүй, мөн химийн хортой, аюултай бодис нэмэлтээр ашиглахгүй, харин тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаас бүтээгдэхүүний нэмэлт бодис гэрээгээр авч ашиглах бөгөөд сав, баглаа боодлыг гэрээний дагуу буцааж нийлүүлнэ.

Ахуйн бохир шингэн хаягдлын хэмжээ: $20 \text{ хүн} \times 45 \text{ литр} = 900 \text{ литр}$, Сард: $900 \text{ литр} \times 30 \text{ хоног} = 27000 \text{ литр}$, Жилд: $900 \text{ литр} \times 246 \text{ хоног} = 221400$

Үйлдвэрт нийт 20 хүн ажилладаг бөгөөд жилд 246 хоног ажиллана гэж үзвэл өдөрт 10 кг, сард 0,3тн ($20 \text{ хүн} \times 0.5 \text{ кг хатуу хог хаягдал/хоногт } 30 \text{ хоног}$), жилд 2,46 тн ахуйн хог хаягдал гарахаар байна.

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	- Ажилчдын үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилж зориулалтын хогийн саванд түр хадгалах замаар ТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу нийлүүлэх - Ахуйн бохир, шингэн хаягдлыг төвийн сүлжээнд нийлүүлэх - Аюултай хог хаягдал буюу автомашины тосыг гэрээт компанид үргэлжлүүлэн нийлүүлэх	Үйлдвэрийн ажилчид	м ² , м ³	250,000	1	1 000 000/жил	Улирал бүр буюу 3, 6, 9, 12 саруудад	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралт. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
	Нийт		1 000 000 (Нэг сая төгрөг)						

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. ОХШХ-ийг жил бүр шинэчлэн боловсруулж тухайн оныхоо эхэнд Нийслэлийн Байгаль орчны газраар батлуулж, оны эцэст тэдгээрийн биелэлтийг мөн тус газарт тайлагнана. Хяналт шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан арга зүй, стандартын дагуу шинжлүүлж үр дүнг тогтмол хуулийн хугацаанд тайлагнах үүрэгтэй юм.



Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	
Агаар орчны бохирдлыг хянах						
1	Тоосонцор PM 10, PM 2.5, Нийт тоосонцор, SO _x , NO _x , Дотоод орчны дуу чимээ	Эзэмшил хашаа, Үйлдвэрийн орчимд буюу 2 цэгт	Жилд 1 удаа	2 000 000	Жил бүр агаарын бохирдолтой улиралд хэмжилт хийх бөгөөд 9 сарын сүүлийн хагаст	MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2	Төслийн халаалтын уурын зуухны яндангаас хаягдах утааны найрлагыг тогтоох хэмжилт	Халаалтын уурын зуух	Жилд 1 удаа	1 500 000	Уурын зуухнаас үүсэх бохирдлыг хянах 9 сарын сүүлийн хагаст буюу галлагаа эхлэх үед	MNS 5457:2005 Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын (CO, SO ₂ , NO _x , үнс) хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга
Хөрсөн бүрхэвч						
3	Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO ₃), хөдөлгөөнт кали (K ₂ O), хөдөлгөөнт фосфор (P ₂ O ₅), механик бүрэлдэхүүн	Эзэмшил хашаанд хөрс бүхий талбайгаас	Жилд 1 удаа	200 000	Хөрсний үржил шимт чанарыг хянах 8 сард	MNS 5546 : 2005
4	Хар тунгалаг (Pb), кадмий (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni)	Эзэмшил хашаанд хөрс бүхий талбайгаас	Жилд 1 удаа	100 000	Хөрсний бохирдлыг хянах зорилготой	MNS 5850:2019



Промон трейд” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Малын гаралтай яс, дайвар бүтээгдэхүүн боловсруулах протейн үйлдвэрийн” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
5	Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ	Түүхий эд хүлээж авах хэсэгт	Жилд 2 удаа	100 000	Хөрсний эрүүл ахуйн бохирдлыг хянах зорилготой 9 сард	MNS 6341:2012
Усны чанар						
6	Унд ахуйн усны ерөнхий үзүүлэлт	Гүний худаг	Жилд 1 удаа	60 000	Ажилчдын унд ахуйн усны чанар, байдлыг тодорхойлох 9 сард	MNS 0900: 2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
7	Усны хүнд металлын шинжилгээ			80 000		
8	Усны эрүүл ахуйн шинжилгээ			60 000		
Ургамлын нөмрөг						
4	Ургамлын зүйлийн жагсаалт, тусгаг бүрхэц	Төсөл хэрэгжих талбай, түүний орчим	Жилд 1 удаа	500 000	ШУА-аас баталсан ургамлын нөөц тогтоох арга зүйг ашиглан 8 сарын эхний хагаст	
Амьтны аймаг						
5	Төслийн талбайд тохиолдох амьтны (шувуу, шавж) зүйлийг бүртгэх	Төсөл хэрэгжих талбай, түүний орчим	Жилд 1 удаа	500 000	Шууд ажиглах аргаар амьтны зүйлийг бүртгэх бөгөөд 8 сарын эхний хагаст хийх нь илүү үр дүнтэй	
Нийт зардал				5 000 000 (таван сая төгрөг)		

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх шаардлагатай. Төслийн үйл ажиллагааны үе шатуудад холбогдох мэргэжлийн байгууллагаар Газрын чанарын улсын хянан баталгаа хийлгэх шаардлагатай. Төслийн үйл ажиллагааны



хугацаанд ажилчдын хөдөлмөр хамгаалал, мэргэжлээс шалтгаалах өвчин, болон бусад олон нийтийг хамарсан цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авах, ажлын байрны эрсдэлийн үнэлгээг мөн мэргэжлийн байгууллагаар хийлгэж байх нь зүйтэй.

АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч “Промон трейд” ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар Нийслэлийн Байгаль орчны газарт тайлан хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сүм, багийн (СХД-ийн 32-р хороо) иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг жил тутамд хийнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 8. БОМТ-ыг оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төгрөг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл
1	СХД-ийн 3Д, Иргэдийн төлөөлөл, Төсөл хэрэгжүүлэгч	Илтгэл, хэлэлцүүлэг	Жил бүрийн 9 сард	1 000 000	Промон трейд ХХК, захирал	СХД-ийн 32-р хорооны Иргэний танхим	Байгаль орчныг хамгаалах, иргэдийн саналыг тусгах
2	Нийслэлийн Байгаль орны газар, төсөл хэрэгжүүлэгч	Тайлан	Жил бүрийн 11 сарын 01-ны дотор	1 000 000	Байгаль орчны мэргэжилтэн	НБОГ	-
БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх нэг жилийн нийт зардал : 2 000 000 (хоёр сая төгрөг)							





МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН
НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар: 0160130

“ЭКО ЭСТИМЭЙТ” ХХК

РЕГИСТРИЙН ДУГААР: 5998808

/Аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар/

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 5., “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. дэх хэсэг, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 4.2., Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 20.17 оны .11 дугаар сарын 23-ны өдрийн А/316 дугаар тушаалыг тус тус үндэслэн дараах чиглэлүүдээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийн гэрчилгээг гурван жилийн хугацаагаар олгов.

Үүнд:

УУЛ УУРХАЙ

ДЭД БҮТЭЦ

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ

ҮЙЛЧИЛГЭЭ

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Н.ЦЭРЭНБАТ

2017 оны 11 сарын 27-ны өдөр



НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		он, сар, өдөр	Гарын үсэг
1.	Мэргэжлийн байгууллагын эрхийг 3 жилийн хугацаагаар сунгав. 2021.01.29	БОАЖСайдын 2021.01.29-ний А/28 дугаар тушаал	ХБОБНУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  Д.БАТМӨНХ
2.	Мэргэжлийн байгууллагын эрхийг 3 жилийн хугацаагаар сунгав. 2024.01.09	БОАЖСайдын 2024.01.09-ны өдрийн А/01 дугаар тушаал	БНБЗГ-ын дарга  Ц.УРАНЧИМЭГ

1119278525-9085084

Энэхүү гэрчилгээг хуулбарлах, олшруулахыг хориглоно.



Холбоо барих хаяг:

Байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний Эко эстимэйт ХХК

Улаанбаатар хот, СБД-ийн 1-р хороо, Чагдаржавын гудамж, 42-46 тоот

Утас: 8921-8282

Цахим шуудан: altangerel@ecoestimate.mn